НҮБ-ЫН ХҮН АМЫН САН МОНГОЛ УЛС

ЖИРЭМСЛЭЛТ БҮР ХҮССЭН, ТӨРӨЛТ БҮР ЭСЭН МЭНД, ЗАЛУУ ХҮН БҮР НӨӨЦ БОЛОЛЦООГОО БҮРЭН ДАЙЧИЛЖ, ХӨГЖЛИЙН ӨНДӨРЛӨГТ ХҮРЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ.

УЛИРАЛ ТУТМЫН МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ №20(4) – 2022 ОНЫ 4-6-Р САР

‘Эсэн мэнд амаржуулчхаад, хүүхдээ амлуулчхаад байж байхад их сайхан’

Хөвсгөл аймгийн Рашаант сумын эх баригч С.Бямбасүрэн

Гуравдугаар сард Хөвсгөл аймагт Монгол улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, НҮБ-ын Хүн амын сангаас хамтран зохион байгуулагдсан “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эх, нярайн яаралтай тусламж” сэдэвт эмнэл зүйн ур чадварт суурилсан сургалтын үеэр Хөвсгөл аймгийн Рашаант сумын эх баригч С.Бямбасүрэнтэй эх баригч нарын асуудлаар ярилцлаа.

С.Бямбасүрэн анх 1990 онд Улаанбаатар хотод Анагаах ухааны дунд сургуулийг Эх баригч багa эмчийн мэргэжлээр төгссөн бөгөөд Рашаант сумд одоог хүртэл тогтвор суурьшилтай 32 жил ажиллаж байгаа юм.

Та хэдэн хүүхэд эх барьж авсан бэ?

Би ажиллах хугацаандаа нийт мянга гаруй хүүхэд эх барьж авсан байна. Би өөрөө таван хүүхэдтэй, хоёр ач, зээтэй. Манай хүүхдүүдийн гурав нь анагаахын мэргэжилтэй. Нэг нь шүдний эмчээр сурч байгаа.

Суманд эх баригчаар ажиллахад ямар вэ?

Миний мэргэжил бол их сайхан мэргэжил. Эхийг эсэн мэнд амаржуулчхаад байж байхад их сайхан. Хамгийн гол нь төрсний дараа эхэс гаргахаас би маш их айдаг. Эсэн мэнд амаржуулчхаад, хүүхдээ амлуулчхаад байж байхад их сайхан. Тэрнээс их аз жаргал гэж байдаггүй. Хүүхэд эсэн мэнд төрүүлэхэд би маш их энерги авдаг. Хөдөөгийн эмэгтэйчүүд чинь эрүүл агаарт амьдардаг, идэж ууж байгаа хоол хүнс нь эрүүл, бас эмч, эх баригчдаа их итгэдэг сайхан хүмүүс байдаг. Бидний өгсөн зөвлөмж зөвлөгөөг сайн дагадаг болохоор бидэнд нэг их айхтар хүндрэл байдаггүй. Гол нь хүн хүнийхээ байдлыг сайн үнэлж, тохируулж ажиллах нь чухал.

Үргэлжлэл 2-р хуудсанд

ЭНЭ ДУГААРТ

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
3-Р ХУУДАС

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ
5-Р ХУУДАС

ӨСВӨР ҮЕ БА ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ
7-Р ХУУДАС

ТҮНШЛЭЛ
9-Р ХУУДАС

‘ЭСЭН МЭНД АМАРЖУУЛЧХААД, ХҮҮХДЭЭ АМЛУУЛЧХААД БАЙЖ БАЙХАД ИХ САЙХАН’

1-р хуудсаас үргэлжлэв

Таныг 32 жил эх баригчаар ажиллахад олон хүндрэл бэрхшээлүүд тулгарч байсан байх. Та тэндээс ямар сургамжуудыг авсан бэ?

Мэдээж хүндрэлүүд гаралгүй яах вэ. 2010 оноос хойш л сумууд гурав, дөрвөн эмчтэй болсон. Ер нь их эмчтэй, ганцхан эрүүл мэндийн даргатай, дүн бүртгэлийн статистикч эмчтэй, бага эмчтэй байдаг. Ер нь их эмчийн хэмжээнд нэг хэсэг ажилладаг л байсан. Хүндрэл бэрхшээлүүд зөндөө гардаг, ганцаараа төрүүлэх үе ч гарна. Сумын бага эмч, эх баригч нар их эмчийн хэмжээнд ажилладаг байсан. Бүх төрлийн үүргийг гүйцэтгэдэг. Хүнээ үзэхээс авхуулаад, дотрын эмчээ ч хийдэг, хүүхдийн эмчээ ч хийдэг. Бараг заримдаа жижиг мэс засал хүртэл хийх шаардлага гардаг.
Умайн гадуурх жирэмслэлт тохиолдох үед цус алдаж, шоконд орох нь түгээмэл болохоор маш их хүндрэл үүсдэг. Ийм үед эмчтэйгээ хоёулаа л шуурхай арга хэмжээ авч ажилдаг. Мэдээж багаар ажиллана л даа, сувилагч нартай. Манай сумын байршлаас болоод дуудлага өгчхөөд хүлээхэд их хэцүү байдаг. Ямар ч байсан бид чадлаараа тусламж үйлчилгээгээ үзүүлдэг. Манай суманд, ямар нэгэн эндэгдэл намайг ажиллах үед, 30 жилд гараагүй.

Энэ бол маш том амжилт байна. Та энэ амжилтын нууцыг хуваалцаач.

Хамгийн гол нь жирэмсний хяналт. Жирэмслэхээс өмнө эхчүүдээ эрүүл байлгах хэрэгтэй. Эрүүл эхээс эрүүл хүүхэд төрнө гэдэг зарчмыг дагадаг. Урьдчилсан сэргийлэх үзлэгт маш сайн хамруулж, жирэмсний хяналтыг маш сайн үр дүнтэй байлгах ёстой. Тэр л хамгийн чухал гэж боддог.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд эх баригчдыг дэмжиж, эх баригчдын үзүүлдэг үйлчилгээнүүдийг бас дэмжих тухай ярж байна. Тань шиг 30 жилийн туршлагатай эх баригчдаа тэтгэвэрт нь гаргаад орхих биш, тэр олон жилийн туршлагыг хойч үедээ авч үлдэх үүднээс таныг зөвлөх эх баригчаар ч юм уу, багшаар ажиллах санал тавивал та хүлээж авах уу?

Зөвшөөрнө. Мэдээж 30 жил ажилсан туршлага байна, хүнтэй харилцах хандлага гэх мэт олон зүйлс байгаа болохоор хамтарч ажиллахад бэлэн. Хөвсгөл аймагт НҮБ-ын Хүн амын сангаас эрүүл мэндийн ажилчдад зохион байгуулсан хоёр өдрийн сургалт маш үр дүнтэй болж байна. Бид маш их мэдээлэлтэй болсон учир цаашдын ажил төлөвлөгөөндөө оруулах олон зүйлийг анзаарсан. Одоо эх баригчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж байгаа юм байна. Бидний зарим нь их эмчтэй адилхан түвшинд ажиллаж байгаа, зарим нь бүүр туслах шиг нь ажиллаж байна. Энэнтэй холбоотойгоор ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж байгааг маш зөв зүйтэй зүйл гэж бодож байна. Мэдээж бас цалин, хөлсний асуудал байна. Сумд ирж ажиллаж байгаа эмч эх баригч нарт цалин хангалтгүй байдаг. Тийм болохоор залуу эмч нар өөр газар эсвэл хувираа ажиллах сонирхолтой байдаг.

Цар тахлаас болоод танхимын сургалт сүүлийн хоёр жил болоогүй, зөвхөн цахим сургалтууд орсон. Тэр хэр их үр дүнтэй байсан бэ?

Үр дүнтэй байсан. Бид хэрэгцээтэй мэдээллээ авч ажилдаа хэрэгжүүлж байна. Гол нь танхимаар сурахаар бид хамтдаа суугаад их ярилцдаг, туршлагаа солилцдог. Манай сум ингэсэн тэгсэн, энийг яаж зохицуулах вэ гээд. Бие биеийнхээ туршлагаас суралцдаг. Өөд өөдөөсөө харж ярилцах нь цахим сургалтаас илүү үр дүнтэй гэж боддог.

Танай суманд жирэмсэн ээжүүдийн Ковид-19-ийн вакцинжуулалт хэр байгаа вэ?

Вакцинжуулалт ерөнхийдөө хийгдчихсэн байгаа. Хоёр дахь тундаа бүгд хамрагдсан. Гурав дахь тун дээр хүмүүсийн хандлага бас жоохон сулраад байгаа. Тэгэхдээ хийгдэж байгаа. Одоо манайд 29 хүн жирэмсний хяналтад байгаа, хоёр дахь тунд 100 хувь хамрагдсан. Гурав дахь тунгийн хамрагдалт 20-30 хувьтай байгаа.

Вакцин дээр зөвлөгөө өгөхөд ямар нэг асуудал тулгарч байна уу?

Харьцангуй гайгүй. Хөдөөгийн хүмүүсийн хандлага нь гайгүй, бас хүлцэнгүй байдаг. Эмчийн зөвлөгөөг сайн хүлээж авдаг. Иргэд интернэт Фейсбүүкээр их мэдээлэл авдаг болсон. Буруу мэдээлэл авсан хүмүүс олон байна. Вакцин хийлгээд ингэсэн, тэгсэн гэнэ гэж хэлэх хүмүүс ирдэг. Тэр болгон дээр хүн, хүнд нь тааруулж харилцаж зөв мэдээллийг өгөхийг хичээдэг.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ

АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН БАГЦ БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), түр хамгаалах байруудад (ТХБ) охид эмэгтэйчүүдэд зориулсан ариун цэвэр, эрүүл ахуйн багц, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний бүртгэл мэдээллийн etuslamj.mn системийн хөгжүүлэлттэй холбоотойгоор НЦҮТ, ТХБ-уудад хэрэгцээтэй тоног төхөөрөмжийг гардуулах үйл ажиллагааг 2022 оны 6-р сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

Нийт 655 ариун цэвэр, эрүүл ахуйн багцын худалдан авалтыг хийж улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 31 НЦҮТ, ТХБ-аар түгээж байгаа ба 100 гаруй сая төгрөгийн үнэ бүхий шаардлагатай тоног төхөөрөмжийг эдгээр газруудад олгож байгаа юм. Үйл ажиллагаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн төргүүн Др. Халид Шарифи, Швейцарын хөгжлийн агентлагийн захирал Др. Стефани Бүрри, тус байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг НЦҮТ, ТХБ-уудын төлөөллүүд оролцлоо.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА БЭХЖҮҮЛЛЭЭ

Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн төргүүн Др. Халид Шарифи Жендэрийн хөтөлбөрийн мэргэжилтнүүдийн хамт Цагдаагийн Ерөнхий Газрын Төргүүн дэд дарга, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Э.Баярбаясгалан төргүүтэй албаныхантай уулзлаа.

Уулзалтын үеэр НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй хэрэгжиж буй "Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь" төслийн хэрэгжилт, үр нөлөө ач холбогдлын талаар ярилцаж, цаашид хүчирхийллийн дуудлага мэдээллийн цуглуулалт, дүн шинжилгээ, тархаалтыг сайжруулах, түүний ач холбогдлын талаар санал солилцлоо.

БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ НЬ

НҮБ-ын Хүн амын сангийн Жендэрийн хөтөлбөрөөс Эрдэнэс Оюу Толгой ХХК-ны үндсэн ажилчдад жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ерөнхий ойлголт, ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр ойлголт мэдлэг олгох сургалтыг 2022 оны 5-р сарын 4-ний өдөр зохион байгууллаа.

2022 оны 5-р сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан Хүмүүнлэгийн багийн ээлжит уулзалтын үеэр жендэр, жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллийн суурь ойлголтууд, тоо мэдээллийн талаар болон зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг, цар тахал гэх мэт онцгой байдлын үед жендэрт суурилсан хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэх, юуг анхаарах талаар сургалт оров.

2022 оны 6-р сарын 30-ны өдөр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төвийн ажилчдад бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зарчмын талаарх ойлголт, энэ нь тэдний өдөр тутмын ажил амьдралд ямар хамааралтай болох талаар мөн хөндлөнгийн ажиглагчаас хүчирхийллийг таслан зогсоох, сэргийлэхэд хэрхэн нөлөөлөгч болох аргазүйн сургалтыг зохион байгуулсан юм.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ХӨГЖЛИЙН ТҮНШҮҮДИЙН УУЛЗАЛТ

Жендэрийн Үндэсний Хороо, Монгол улсын Гадаад харилцааны яам (ГХЯ), НҮБ-ын Хүн амын сантай хамтран 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй (ЖСХ) тэмцэх хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах нь" сэдэвт хөгжлийн түншүүдийн улирал тутмын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтын үеэр Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Монгол дахь агентлагууд, дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагуудын төлөөлөл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, боломжуудын талаар арга зүйн хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдааг сайжруулах талаар санал солилцлоо. ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра нар уулзалтыг нээж, Монгол Улсад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд гаргасан ололт амжилтыг онцлон тэмдэглэв. Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Др. Халид Шарифи Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, НҮБ-ын Хүн амын сангийн 2023-2027 он хүртэлх улс орныг дэмжих хөтөлбөрийн талаар танилцуулсан юм.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦЫН ТАЙЛАН

Монгол улсын Засгийн газар Нэгдсэн үндэстний байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хорооны 82-р хуралдаанд цахимаар оролцон “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 10-р тайланг хэлэлцүүлэн хамгааллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тайланг хамгаалах ажлын хэсгийн хэлэлцүүлгүүдийг 6-р сарын 3-наас үе шаттай зохион байгуулж 6-р сарын 23-24-ний өдрүүдэд тус тайланг хамгаалсан юм. Тус ажлыг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд дэмжин ажилласан юм.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭХИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй “Ковид-19 цар тахлын үед Эхийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах нь” төслийн хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын 40 эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт зориулсан Эх барихын яаралтай тусламжийн сургалтыг 2022 оны 6 дугаар сарын 27-28 өдрүүдэд Дархан-Уул аймгийн ЭМГ-т зохион байгуулав.

Энэхүү тохиолдолд суурилсан, гардан үйлдэл давамгайлсан сургалтыг ЭХЭМҮТ, АШУҮИС, Өргөө амаржих газрын сургагч багш нар удирдан чиглүүлсэн юм. Сургалтыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны ахлах мэргэжилтэн Ж.Чимгээ, Дархан-Уул аймгийн ЭМГ-ын дарга Б.Батцэнгэл нар нээж үг хэлэв. НҮБ-ын Хүн амын сангийн зүгээс “Эх яагаад эндэв?” судалгааны дүгнэлт, жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд Ковид-19-ийн эсрэг дархлаажуулалтын ач холбогдлын талаар танилцуулга хийв.

КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ, АЧ ХОЛБОГДЛООР ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЗААВАР ГАРГАВ

Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын ач холбогдлын талаар хийгдсэн судалгаа, шинжилгээ, олон улсын удирдамжуудаас жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд зайлшгүй өгөх мэдээллүүдийг нэгтгэн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч нарт зориулсан зөвлөгөө өгөх заавар боловсруулаа. Энэхүү зааврыг Эрүүл мэндийн яамны эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөлөөр баталгаажуулж, үндэсний хэмжээнд аймаг, сум орон нутгийн эмч нарт түгээв.

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭРЭГСЛЭЛ, БИЧИЛ ТЭЖЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

НҮБ-ын Хүн амын сан Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл, бичил тэжээлийн хүртээмжийн талаарх судалгааг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран санхүүжүүлж мэдээлэл цуглуулах ажиллыг гүйцэтгэв. Судалгааг ЭХЭМҮТ-ын эрдэм шинжилгээний баг гүйцэтгэж байгаа бөгөөд одоо статистик шинжилгээ, дүгнэлт гаргах ажилдаа шилжээд байна.

ОЛОН УЛСЫН ЭХ БАРИГЧИЙН ӨДРИЙГ “100 ЖИЛИЙН ЗАМНАЛ” СЭДВИЙН ДОР ТЭМДЭГЛЭВ

Энэ жилийн Олон Улсын Эх баригчийн өдрийг эх барихуйн “100 жилийн замнал” сэдвийн дор Эрүүл мэндийн яам, Монголын Эх баригч нарын нийгэмлэг тэмдэглэв. Энэхүү арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Б.Саранчимэг, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар оролцож, НҮБ-ын Хүн амын сангийн Ази, Номхон далайн бүсийн захирал Бйорн Андерсон, Олон улсын Эх баригч нарын холбооны тэргүүн Франка Кади нар цахимаар мэндчилгээ ирүүлсэн байна.

Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн Др. Халид Шарифи НҮБ-ын Хүн амын сангийн Эх баригчийг дэмжих дэлхийн стратегийг танилцуулав.

Тэмдэглэлт уулзалтын үндсэн зорилго нь Монголын эх баригч нарыг дууг шийдвэр гаргагч нарт хүргэх байв. “Эх баригч нар юуг хүсэж байна” хүсэлтийг Монгол Улсын Их хурал, Засгийн газар, НҮБ-ын төлөөлөгч нарт гаруулав. Энэхүү хүсэлтэд эх баригч нарыг эрх мэдэл, үргэлжилсэн сургалтаар хангаж хэвийн жирэмслэлт, төрөлтийг бие даан удирдах, гэр бүл төлөвлөлт, өсвөр үеийнхний эрүүл мэндийн асуудлаар тусламж үйлчилгээ үзүүлэх бололцоогоор хангахыг шаардсан байна.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛИЙН ЭСРЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

НҮБ-ын Хүн амын сангийн арга зүйн дэмжлэгтэйгээр Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбоотой хамтран зургаан аймаг (Сүхбаатар, Дундговь, Сэлэнгэ, Архангай, Увс, Ховд) болон Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулсан “Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээ” сургалтыг 2022 оны хоёрдугаар улиралд зохион байгууллаа.

Тус сургалтад эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, эх баригчид, өсвөр үеийнхний эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, гэмтлийн чиглэлээр мэргэшсэн нийт 105 эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч хамрагдаж эмнэл зүйн тусламж үйлчилгээний удирдамжаар сургагдлаа.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ “НИСЛЭГИЙН ӨМНӨХ ХӨТӨЛБӨР” ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

Өсвөр насныхан бие даан амьдрах, шийдвэр гаргахад шаардлагатай бэлгийн болон нөхөн үржихүйн цогц боловсрол олгох зорилготой “Нислэгийн өмнөх хөтөлбөр” хэрэгжиж эхэллээ.

2022 оны 4-р сарын 8-ны өдөр Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан Өвөрхангай аймагт "Нислэгийн өмнөх хөтөлбөр" -ийг эхлүүлж, залуучуудад чанартай эрүүл мэндийн боловсрол, тэр дундаа бэлгийн харилцааны цогц боловсрол олгох бусад арга хэмжээг өргөжүүлэв.

НҮБ-ын Хүн амын сан аймгийн төв болон Улаанбаатар хотод дээд боловсрол эзэмшихээр зорьж буй ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад зориулсан "Нислэгийн өмнөх хөтөлбөр" -ийг санаачилж, боловсруулсан юм.

"Нислэгийн өмнөх хөтөлбөр" -ийн нээлтийн арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Өвөрхангай аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын холбогдох албаны төлөөлөл болон тус хөтөлбөрт оролцогч өсвөр үеийнхэн оролцлоо.

НҮБ-ын Хүн амын сан, Юнител ХХК нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран 2022 оны 6-аар сарын 9-ний өдөр Дархан-Уул аймагт “E-Hub” цахим номын санг нээлээ. Уг санаачилгын хүрээнд Юнител ХХК нь 21 аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн нэг өрөөг "E-Hub" болгон тохижуулах юм. Энэхүү төвүүд нь өсвөр үе, залуучуудад үнэ төлбөргүй цахим ном, цахим контент болон бусад сурах арга хэрэгслийг ашиглан мэдлэг, боловсрол эзэмшүүлэх боломжийг олгоно.

Дархан-Уул аймгийн “E-Hub” төвийн нээлтийн үйл ажиллагаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Г.Батдорж, Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга А.Амгалан, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Др. Халид Шарифи, Юнител ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Энхбат болон Дархан-Уул аймгийн хүүхэд залуучууд оролцов.

НҮБ-ын Хүн амын сан, Юнител ХХК нь 2022-2023 онд үе шаттайгаар бусад 20 аймгийн Залуучуудын хөгжлийн төвүүдэд E-Hub байгуулах юм.

ОРОН НУТГИЙН ЗАЛУУЧУУДЫН НАЙДВАРТАЙ МЭДЭЭЛЭЛ, МЭДЛЭГ ОЛЖ АВАХ БОЛОМЖИЙГ ДЭМЖИВ

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ЦАХИМ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЦУВРАЛ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

НҮБ-ын Хүн амын сан НҮБ-ын Залуучуудын ажлын хэсгийг 2022 онд ахалж байгаа ба Залуучуудын хөгжлийн төв (ЗХТ)-ийн ажилтнуудыг бусад НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран чадавхжуулах жилийн төлөвлөгөө боловсруулсан. Төлөвлөгөө ёсоор Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сан 2022 онд ЗХТ-ийн ажилтнуудад цахим сургалт явуулахаар төлөвлөж байна. Сургалтын гол зорилго нь ЗХТ-ийн ажилтнуудад олон талт, орчин үеийн мэдлэг, мэдээлэл олгох замаар залуучуудад хүргэх үйлчилгээний чанарыг сайжруулах юм.

Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран 6-р сард жендэртэй холбоотой сэдвээр сургалт явуулж, цуврал сургалтуудыг эхлүүллээ. Эдгээр байгууллагуудын мэргэжилтнүүд болон НҮБ-ын Хүн амын сангийн мэргэжилтнүүд үндэсний хэмжээний ЗХТ-ийн 60 албан хаагчдад жендэрийн сэдвээр нийт таван цагийн цахим сургалт хийлээ. Энэхүү сургалтаар ЗХТ-ийн ажилтнууд жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн талаарх ойлголттой танилцаж, холбогдох улсын байгууллагуудын эдгээр чиглэлээр хийж байгаа ажилтай танилцлаа.

Чадавхыг бэхжүүлэх цуврал сургалт 2022 он дуустал үргэлжлэх бөгөөд гэр бүл төлөвлөлт, БЗДХ/ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, залуучуудын хөдөлмөрлөх эрх, сайн дурын үйл ажиллагаа, хүний наймааны эсрэг болон бусад олон сэдвүүдийг хамрах юм.

НҮБ-ЫН ХҮН АМЫН САН 2022 ОНД ХӨГЖЛИЙН ТҮНШҮҮДИЙН ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО СЭДЭВТ АЖЛЫН ХЭСГИЙГ АХАЛЖ БАЙНА

НҮБ-ын Хүн амын сан нь АНУ-ын Энхтайвны корпустай хамтран 2022 онд Хөгжлийн түншүүдийн Залуучуудын оролцооны ажлын хэсгийг ахалж байна. Ажлын хэсгийн анхны биечлэн уулзалт 2022 оны 6-р сарын 13-нд НҮБ-ын байранд болсон ба уулзалтад АНУ-ын Энхтайвны корпус, Швейцарын хөгжлийн агентлаг, Каритас Чех Репаблик байгууллага, Лоринет сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчид оролцлоо. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга О.Сэлэнгэ Засгийн газрын төлөөлөгчөөр оролцож, Монгол Улсын залуучуудын асуудал, залуучуудыг хөгжүүлэхтэй холбоотой үндэсний тэргүүлэх чиглэлүүдийн тоймыг танилцууллаа. Хуралдаанд оролцсон түншүүд залуучуудын хөгжлийн чиглэлээр хийж буй ажлаа танилцуулж, илүү сайн үр дүнд хүрэхийн тулд ажлаа хэрхэн нэгтгэх талаар товч ярилцаж, санал солилцсон. Ажлын хэсэг 2022 онд шинээр байгуулагдсан тул залуучуудын хөгжлийн чиглэлээр хийж буй ажлуудаа хэрхэн уялдуулах талаар хэлэлцүүлгийг өрнүүлж, дараа дараагийн хурлаар хэлэлцэхээр тохиролцлоо.

НҮБ-ЫН ХҮН АМЫН САН ОРОН НУТАГТ АЖИЛЛАА

НҮБ-ын Хүн амын сан 2022 оны 4-өөс 6-р саруудад Архангай, Завхан, Ховд, Баян-Өлгий, Сүхбаатар, Дорнод аймгуудад ажиллаа.

Архангай, Завхан аймгуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл (ГХУСАЗЗ), НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) ажилласан бөгөөд ГХУСАЗЗ-ийн ахлах мэргэжилтэн Ч.Амарбаясгалан, ШХА-ын төв оффисын Монгол улсыг хариуцсан мэргэжилтэн Сузанне Амслер, Монгол дахь ШХА-ийн хамтын ажиллагааны дэд дарга Бенуа Мейер-Бийш нар оролцсон юм.

Ховд, Баян-Өлгий аймгуудад 5-р сард дээд хэмжээний айлчлалыг зохион байгуулсан бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Э.Баярбаясгалан, НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Др. Халид Шарифи, ШХА-ийн захирал Стефани Бүрри нар оролцсон бол 6-р сард Сүхбаатар, Дорнод аймгуудад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Халид Шарифи нар ажиллаа.

Энэхүү ажлын нэг гол зорилго нь ШХА-ийн санхүүжилтээр Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хэрэгжилттэй танилцах явдал байсан бөгөөд айлчлалын үеэр орон нутгийн засаг захиргаа, холбогдох албаныхан болон хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), түр хамгаалах байрны (ТХБ) үйлчилгээ үзүүлэгчидтэй уулзсан.

Эдгээр аймгуудад ажиллах үеэр орон нутгийн түвшинд хохирогч хамгааллын механизм болон салбар дундын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан байгааг албаныхан онцлон тэмдэглэсэн юм. Архангай, Завхан, Ховд, Баян-Өлгий аймгуудын НЦҮТ, ТХБ-ууд эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх санаачилгуудыг амжилттай хэрэгжүүлж байгаа ба тэдгээр санаачилгууд нь төвөөр үйлчлүүлэгчдийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, тэдэнд хүчирхийлэл үйлдэгчээс ангид бие даан амьдрах чадваруудыг эзэмшүүлж цаашлаад хүчирхийллийн тойргоос гарах боломжийг олгож байгаагаараа онцлогтой. Сүхбаатар аймгийн ТХБ 5-р сард нээлтээ хийн ажиллаж эхэлсэн бөгөөд орон нутгийн төсвөөс 90 сая төгрөгийг хохирогч хамгааллын механизмыг бэхжүүлж, ТХБ-ны үйл ажиллагааг дэмжихэд төсөвлөсөн бол Дорнод аймгийн НЦҮТ хамтарсан багаар дамжуулан салбар дундын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд ахиц гарган ажиллаж байна.

Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал НҮБ-ын Хүн амын сангийн багийнхантай уулзав

Архангай аймгийн ИТХ-ын дарга Б.Батжаргал НҮБ-ын Хүн амын сангийн багийг хүлээн авч уулзав

Дорнод аймгийн Засаг даргын орлогч Ш. Ёл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар болон НҮБ-ын Хүн амын сангийн багтай уулзав

Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн Др. Халид Шарифитай уулзав

Ховд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав НҮБ-ын Хүн амын сангийн багийн хамт

Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржан НҮБ-ын Хүн амын сангийн багийн хамт

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНГААС САНХҮҮЖҮҮЛСЭН МАЛЧДЫН ЦОЧРОЛЫГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХААЛТАА ХИЙВ

“Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” НҮБ-ын хамтарсан хөтөлбөр (2020-2022) амжилттай хэрэгжиж 2022 оны 6-р сарын 27-ны өдөр Удирдах хорооны хаалтын хурал зохион байгуулагдав. Тус хурлаар хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлээгийн үр дүнтэй танилцаж цаашид хөтөлбөрийн үр шимийг тогтвортой хадгалах асуудлаар хэлэлцэв.

2022 оны 2 дугаар улиралд Завхан аймгийн малчдын чуулган, төслийн оролцогч талуудын уулзалт зэрэг томоохон арга хэмжээнүүд зохион байгуулагдаж хөтөлбөрийн үр дүн, цаашдах тогтвортой байдлын талаар хэлэлцүүлэг хийгдэв.

Малчдын чуулганы үеэр уг хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй Завхан аймгийн таван суманд хэрэгжсэн 14 гарааны бизнесийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж орон нутгийнхны сайшаалыг хүртэв. Энэхүү хөтөлбөр нь Завхан аймгийн таван аймгийн 14 малчдын хоршооны малчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулж, нийгмийн хамгааллын санхүүжилтийн стратегийг боловсруулж, Засгийн газарт танилцуулсан.

ТАЛАРХАЛ

Жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд, залуу хүн бүр нөөц бололцоогоо бүрэн дайчилж, хөгжлийн өндөрлөгт хүрэх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хүчин чармайлтыг үргэлж дэмждэг хандивлагчид, түншүүд, үр шит хүртэгчиддээ баярлалаа.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛ:

Б. Хаш-Эрдэнэ
Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн ажилтан

Имэйл: bayarsaikhan@unfpa.org

Visit us at mongolia.unfpa.org

www.facebook.com/UNFPA.Mongolia

twitter.com/UNFPA_Mongolia

www.instagram.com/unfpa_mongolia/